



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 8 дугаар
сарын 31-ний өдөр


Дугаар 70

Улаанбаатар
хот

Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн
батлах тухай

Хүнсний тухай хуулийн 18.4 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүн батлах тухай” Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 78 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 49 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн
үйлдвэрийн сайд

П.СЭРГЭЛЭН

ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ахлагч -Монгол Улсын Ерөнхий сайд
- Орлогч дарга -Монгол Улсын Шадар сайд;
-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд.
- Гишүүд:
-Байгаль орчин, аялал жуулчлалын сайд;
-Эрүүл мэндийн сайд;
-Үндэсний статистикийн хорооны дарга (зөвшилцсөнөөр);
-Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Үндэсний хөгжлийн газрын дарга;
-Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга;
-Гаалийн ерөнхий газрын дарга;
-Татварын ерөнхий газрын дарга;
-Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга;
-Стандартчилал, хэмжил зүйн газрын дарга;
-Тагнуулын ерөнхий газрын Тэргүүн дэд дарга;
-Онцгой байдлын ерөнхий газрын бодлого, сургалт хариуцсан дэд дарга;
-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;
-Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн газрын дарга;
-Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хүнсний асуудал хариуцсан референт (зөвшилцсөнөөр);

- Улаанбаатар хотын Ерөнхий менежер;
 - Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн захирал;
 - Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн захирал;
 - Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн захирал;
 - Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн үндэсний холбооны захирал (тохиролцсоноор);
 - Монголын хүнсчдийн холбооны гүйцэтгэх захирал (тохиролцсоноор).
- Нарийн бичгийн дарга: -Хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан Засгийн газрын референт.

---o0o---

